

Клиникийн Хоёрдугаар Амаржих газар

Тус амаржих газар нь СнЗ-ийн /Хуучин нэрээр/ тогтоолоор 1959оны 24-энд одоогийн Хануул дүүргийн нэгдсэн эмнэлэгт 4 ортой төрөх тасаг нээгдсэнээр суурь нь тавигдсан. Улмаар 1959 оны 12 дугаар сарын 10-нд одоогийн байранд 150 ортойгоо 2 дугаар амаржих газар нэртэйгээр нээгдсэн байна.

Амаржих газар нээгдсэнээс хойш 200 мянга гаруй эх төрүүлж, олон арван мянган эхчүүдийг эмчлэхэд тус амаржих газрын тулгын чулууг тавилцсан Г.Дуламжав, О.Должинсүрэн, Д.Ичинхорлоо, Д.Эрдэнэжав, Ё.Очирсүх, Д.Сильва, Д.Дүвжир, О.Сэрээтэр, Д.Банхан, Т.Арилла, Д.Ганбаатар, нарын ахмад эмч нар жинтэй хувь нэмэр оруулжээ.

2006 оноос одоог хүртэл ерөнхий эмчээр Б.Оюуханд ажиллаж байна. Тус амаржих газраас хүний гавьяат эмч Г.Дуламжав, О.Должинсүрэн, Сүхбаатарын одонт эмчээр Г.Дарь, "Алтан гадас" одонгоор сувилагч Д.Отгон Д.Уртнасан шагнагдсан.

Бүтэц үйл ажиллагаа:

Одоо тус амаржих газар нь Захиргаа, аж ахуйн, эмчилгээний 4 тасаг, 75 ор 105 эмч ажилчид тайгаар СХД-ийн 49000 гаруй нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд эх барих, нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг чанарын өндөр төвшинд үзүүлж жил бүр 3800 гаруй эхчүүдийг эсэн мэнд амаржуулаад байна. Тус амаржих газрын эмч мэргэжилтний 50 гаруй хувь нь тэргүүлэх, ахлах зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байна.